

Санхүүгийн туслалцааны бодлогын энгийн хэл найруулгаар бичсэн хураангуй

НордШоор их сургуулийн эрүүл мэндийн систем (НордШоор гэх)-ээс гачигдалтай өвчтөнүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх бодлогыг баримталдаг. НордШоор Санхүүгийн Туслалцааны бодлогын (FAP-СТБ) шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүгийн туслалцаа авах шаардлагыг хангасан хувь хүнд үнэ төлбөргүйгээр, эсвэл хөнгөлсөн дүнгээр яаралтай тусламжийн болон эмнэлгийн шаардлагатай үйлчилгээг үзүүлнэ. СТБ-ын шалгуурыг хангасан өвчтөнүүд эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд даатгалд хамрагдсан өвчтөнүүдэд ерөнхийдөө ногдуулдаг дундаж дүнгээс (ДД) илүү дүнгээр төлбөр тооцогдохгүй.

Санхүүгийн туслалцаа авах эрх бүхий байдлыг тогтоохдоо орлого, гэр бүлийн гишүүдийн тоо, Холбооны Ядуурлын Түвшин (ХЯТ) зэрэгт суурилдаг. ХЯТ нь өрхийн ам бүлийн тооноос хамааран өөр байх ба жил бүр шинэчлэн тогтоогддог.

Доорх хүснэгтээр санхүүгийн туслалцаа авах эрх бүхий байдлын шалгуур үзүүлэлтийг хураангуйлан үзүүлэв. Санхүүгийн туслалцаа болон Үндэслэлтэй эрх бүхий байдлын шалгууруудын талаарх нэмэлт мэдээллийг СТБ-оос авч болно.

Санхүүгийн туслалцаа	Хэн авах боломжтой вэ	ХЯТ	Тодорхойлолт	Хэрхэн хүсэлт гаргах вэ
Үнэ төлбөргүй үйлчилгээ	Даатгалгүй болон даатгалтай өвчтөнүүд	0% - 200%	Үндэслэлтэй эрх бүхий байдал эсвэл ам бүлийн тоо ба орлогод суурилна. (ХЯТ)	Үндэслэлтэй эрх бүхий байдлаа нотлон харуулах эсвэл хүсэлтийн маягт бөглөх
Ялгавартай хэмжээгээр хөнгөлөлт эдлэх	Даатгалгүй болон даатгалтай өвчтөнүүд	201% - 400%	Ам бүлийн тоо ба орлогод суурилна. (ХЯТ)	Хүсэлтийн маягт бөглөх
Ялгавартай хэмжээгээр хөнгөлөлт эдлэх	Зөвхөн даатгалгүй өвчтөнүүд	401% - 600%	Ам бүлийн тоо ба орлогод суурилна. (ХЯТ); Нийт 300 ам доллар эсвэл түүнээс илүү төлбөртэй Иллиноисийн даатгалгүй иргэдэд хамаарна	Хүсэлтийн маягт бөглөх

Санхүүгийн туслалцааны бичиг баримтуудыг (бодлого, хураангуй, хүсэлтийн маягт гэх мэт) НордШоорын вебсайтаас www.northshore.org/about-us/billing/financial-assistance эсвэл www.swedishcovenant.org/for-patients-and-visitors/pay-your-bill/hospital-financial-assistance-policy авах боломжтой бөгөөд эмнэлгийн бүртгэлийн хэсгээс хэвлэсэн хувийг үнэ төлбөргүйгээр авч болно. Мөн эдгээр бичиг баримтыг доор дурдсан дугаараар залгаж эсвэл шуудангаар хүлээн авч болно. Эдгээр бичиг баримт нь мөн испани, орос, солонгос, сири, араб, вьетнам болон польш хэлээр боломжтой, ба монгол.

Үндэслэлтэй эрх бүхий биш бол хүсэлтийг (нэмэлт бичиг баримтын хамт) дор жагсаасан хаягаар шуудангаар эсвэл эмнэлгийн санхүүгийн зөвлөхөд аль болох богино хугацаанд, үйлчилгээний анхны төлбөрийн мэдүүлэг ирснээс хойш 240 хоногийн дотор ирүүлнэ.

Бөглөсөн хүсэлтийг илгээх:	Тусламж хэрэгтэй юу? Бид тусалж чадна.
<p>Шуудангаар: НордШоор Их сургуулийн Эрүүл мэндийн систем Өвчтөний санхүүгийн үйлчилгээ Шуудангийн хайрцаг 1006, Салбар 330 Скоки, Иллинои 60076-9877</p> <p>Факсаар: (847) 982-6957</p> <p>Биечлэн: Эмнэлгийн бүртгэлийн хэсэгт очиж эмнэлгийн санхүүгийн зөвлөхөд авчирч өгөх</p>	<p>(847) 570-5000 руу залгах</p> <p>эсвэл эмнэлгийн бүртгэлийн хэсэгт очиж, эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзаарай.</p>

Бөглөсөн хүсэлтийг илгээх:	Тусламж хэрэгтэй юу? Бид тусалж чадна.
<p><u>Шведийн эмнэлгийн хувьд:</u> <u>Шуудангаар:</u> Шведийн эмнэлэг Санхүүгийн үйлчилгээний төв 5145 Хойд Каролина өргөн чөлөө Чикаго, Иллиной 60625 <u>Факсаар</u> (773) 878-6838 <u>Биечлэн:</u> Эмнэлгийн бүртгэлийн хэсэгт очиж эмнэлгийн санхүүгийн зөвлөхөд авчирч өгөх</p>	<p>Шведийн эмнэлгийн хувьд: (773) 989-3841 руу залгах эсвэл эмнэлгийн бүртгэлийн хэсэгт очиж, эмнэлгийн санхүүгийн зөвлөхтэй уулзаарай.</p>